



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/514

Булган сум

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль  
зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3, 32.1.7, 32.1.8, 32.1.10, 51 дүгээр зүйлийн 51.2 дах заалт, Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн хэрэгжүүлэх 2025 оны ШС-25/004 дүгээр гэрээний 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Булган аймагт 2025 оны 09 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль"-ийн бэлтгэл ажлыг хангахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах зардалд 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийг Булган аймгийн 2025 оны батлагдсан төсвийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.


3. "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль"-ийн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, удирдлага, зохицуулалтаар ханган, үр дүнтэй зохион байгуулахыг Засаг даргын орлогч (О.Ундрах), Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр), үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг байгууллага, аж ахуй нэгж, төрийн өмчит хувьцаат компани (Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг)-ийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай.

4. Бараа, бүтээгдэхүүн худалдан авах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангид дэмжлэг үзүүлэх зардлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, байгууллагын данс бүртгэлд тусгаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Н.Хишигдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА


Д.ПҮРЭВ-ОЧИР

Сугар Ажил 2025 өдөр бүр Дос/2025/Захирамж



6325010708

Аймгийн Засаг даргын 2025 оны  
07 дугаар сарын 25-ны/ний өдрийн  
А/514 дугаар захирамжийн хавсралт



БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

д/д	Бараа, бүтээгдэхүүний нэр	Тоо ширхэг	Нэг бүр үнэ /мянга, төг/	Нийт үнэ /мянга,төг /	Байгууллага, аж ахуйн нэгж
1	Иргэдэд мэдээлэл хүргэх танилцуулга хэвлэх болон бусад бичиг хэргийн зардал	-	-	2,500.0	Онцгой комисс
2	Хэвлэл, эх бэлтгэл, ГХА, МА-н нэр бүхий самбар, хулдаасан хэвлэл, аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ	-	-	2,500.0	ОБГ, Гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн анги
3	ОК-н даргын ажлын болон шийдвэрийн зураг хэвлэх, бэлтгэхэд	2	383000	766.0	ОБГ, ГХБХБГ
4	Шатахуун, шатах тослох материал	3000 л	ДТ-3030	9,090.0	Оролцох гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн техник хэрэгсэл /ЦГ, ЭМГ, МЭГ, ОБГ, ЭБЦТСТӨХК, Булган мээж ОНӨХХК, Булган АЗЗА-ТӨХК, Булган сум, Нэгдсэн эмнэлэг, АЗДТГ, УЦУОШТ, ГХБХБГ, БОГ, ХХААГ, АТҮТ-н Булган салбар, техник дайчлах аж ахуйн нэгж/
		2000 л	Бен-2720	5,440.0	
5	Цахилгааны утас, холбох тоног төхөөрөмж, хэрэгсэл	Ком	-	1,000.0	Эрчим хүчээр хангах алба
6	Тактикийн дадлагын штабын болоод мэргэжлийн ангиудын байр	Хээрийн удирдлагын байр 6x4м-2ш	2,500.0	5,000.0	Онцгой комисс
7	Хээрийн эмнэлэгт, Платки	Майхан 4x4-4ш,	900.0	17,200.0	Онцгой комисс, ГХА, МА-д
		Майхан 8x5-2ш,	1,800.0		
		Майхан 6x12-2ш	5,000.0		
8	Цахилгаан үүсгүүр	1	5,000.0	5,000.0	Онцгой комисс
9	Мотопомп	1	1,000.0	1,000.0	Мал эмнэлгийг газар
10	Усны сав 1 тн	2	500.0	1,000.0	Онцгой комисс,
					Эрүүл мэндийн газар
11	Өвчтөн тусгаарлах хаалт	5	395.0	1,975.0	Эрүүл мэндийн газар

12	Цус цуглуулах машины хөргүүр	2	400.0	800.0	
13	Эвхдэг ор	40	180.0	7,200.0	Онцгой комисс
14	Халдвар хамгааллын хувцас хэрэгсэл	200	10.0	2,000.0	Мал эмнэлгийн газар
15	Хөдөлгөөнт удирдлагын байр бэлтгэх	-	-	17,629.0	Онцгой комисс
16	<b>Ангиллын сургалт зохион байгуулах</b> (удирдах албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтын, ажилтны, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны, иргэний)	6	-	2,000.0	Онцгой байдлын газар Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн
17	Ойлголттой хантааз	20	30.0	600.0	Булган "АЗЗА" ТӨХК
18	ОП цув	3	100.0	300.0	
19	Цацраг, химийн аюулын үеийн хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэгсэл	4	250.0	1,000.0	Ус цаг уур, орчны шинжилгээний төв
20	Аймаг, сумын ажлын зураг энгэт хэвлэгчээр хэвлэх, хор, зургийн цаас	74	1,000.0	1,000.0	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
21	Удирдах албан тушаалтын бие бялдар сэтгэлзүйн сорил дасгал	27	-	1,000.0	Сорил дасгалын талбай, цэгийн бэлтгэл ажлыг хангах, хээрийн дадлага
22	Сургууль зохион байгуулах алба хаагчдын хоол, хүнсний зардал	-	-	4,000.0	Бэлтгэл ажлыг хангуулах, сургууль зохион байгуулах /өглөө, өдөр, орой хоол/
23	Иргэдийг аюулгүй талбайд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа	-	-	10,000.0	Аюулгүй талбайн бэлтгэл ажлыг хангах, хээрийн нөхцөлд кемп байгуулах
Дүн					100,000,000